



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 11 өдөр

Дугаар А/393

Мандалгони

Г Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг
томилох тухай

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын Сайдын 2018 оны А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Ёс зүйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам"-ын 2.1, 2.3 заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Боловсролын салбарын ажилтан, албан хаагчид албан үүргээ гүйцэтгэхэд баримтлах зарчим, даган биелүүлэх ёс зүйн хэмжээ зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах болон бусад ажилтны ёс зүйн зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Зөвлөлийн дарга: О.Бат-Эрдэнэ (Аймгийн Засаг дарга)
Нарийн бичгийн дарга: Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)
Гишүүд:
Б.Хандмаа (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Б.Цэцэг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн)
С.Алимаа (Сайнцагаан сумын 4 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч)
А.Очирбат (Сайнцагаан сумын Эрдмийн далай цогцолбор сургуулийн сургалтын менежер)
Т.Мөнхбат (Сайнцагаан сумын Цэгц билиг сургуулийн багш)
Г.Цолмон (Луус сумын Сургуулийн нийгмийн ажилтан)
Д.Галбадрах (Эцэг эхийн төлөөлөл)

Хоёр. Ёс зүйн зөвлөлд Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/243 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан журмыг мөрдөж ажиллахыг даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

488010264